



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 27 өдөр

Дугаар А/367


Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Баруун Монгол түмний ардын дуу, бий биелгээ, дуудлага, хархираа, хөөмий, Алтайн магтаал багтсан кино контентийг Улс орон даяар тв сувгаар гаргах зардалд 5 000 000 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.
2. Зардалд зарцуулагдах 5 000 000 төгрөг /Таван сая/-ийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 4.5-д заагдсан "Олон үндэстэн ястны өв соёл" хөтөлбөр арга хэмжээнээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Б.Даваадорж/ нарт зөвшөөрсүгэй.
3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2021 оны
07 дугаар сарын 27-ны өдрийн
А/367 дугаар захирамжийн хавсралт



КИНО КОНТЕНТИЙГ УЛС ОРОН ДАЯАР
ТВ СУВГААР ГАРГАХ ЗАРДАЛ

ДД	Ажлын нэр	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Мөнгөн дүн /төгрөг/
1.	Кино кран түрээслэх	2 өдөр	750 000	1 500 000
2.	Тайзны түрээс	2 өдөр	320 000	640 000
3.	Ерөнхий зураглаач, Эвлүүлэгчийн цалин	1 ш	2 000 000	2 000 000
4.	Туслах ажилтан, кранист цалин	2 ш	300 000	600 000
5.	Диктор, хоолой уншуулсан хөлс	1 ш	260 000	260 000
НИЙТ ДҮН				5 000 000

-оОо-